



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/305


Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/ , 29.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4.2.2 дахь заалтад тусгасан Насан туршийн боловсрол төвийг түшиглэн зохион байгуулах ардын өв уламжлал, зан заншил, амьдрах ухаан хөтөлбөр болох “Өв уламжлал бидний амьдралд” төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардалд 5000000 /Таван сая/ төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2.Шаардагдах зардал 5000000 /Таван сая/ төгрөгийг төсөл хөтөлбөрийн “Насан туршийн боловсрол төвийг түшиглэн ардын өв уламжлал, зан заншил, амьдрах ухааны сургалтыг явуулах” арга хэмжээний зардлаас төсвийн хуваарийн дагуу гаргахыг Санхүү, Төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д. БАТЛУТ